

Нүдний мэргэжилтэнд зэрэг олгох тусгай шалгуур

Нэг. Нүдний ахлах зэрэг хамгаалах эмчийн тусгай шалгуур:

1. Нүдний резидентийн сургалт дүүргэсэн, хүн амд нүдний шинжлэх ухааны оношлогоо, эмчилгээний тусламжийг аймаг, хот, дүүргийн эмнэлгийн хэмжээнд бүрэн үзүүлэх онол дадлагын мэдлэгтэй, бүтээлтэй байна.
2. Нүдний эмгэгтэй өвчтөнд птериgium авах, эргэсэн зовхийг засах, нүдний нэвт гэмтлийн шархны цэгцлэлт, иридэктоми, синустрабекулэктоми, энуклеац, эвисцерац, хялрын мэс засал, болрын экстракапсуляр экстракц гэх мэтийн мэс заслын болон шил тааруулах онолын мэдлэгтэй буюу хийх ур чадвартай байна.
3. Мэргэжил нэгт эмч нартаа хүндэтгэлтэй харьцдаг, ёс зүйн алдаа гаргадаггүй байх
4. Жил бүр нэгээс доошгүй удаа мэргэжлийн богино хугацааны сургалтанд хамрагдсан байх
5. Англи болон бусад гадаад хэлний мэдлэгтэй, нүд судлалын сэтгүүл, ном, мэдээллийг уншдаг, орчуулга хийх чадвартай байх
6. Мэргэжлийн болон эрүүл мэндийн чиглэлийн сэтгүүлд 3-с доошгүй нийтлэл болон эрдэм шинжилгээний өгүүлэл бичсэн байх

Хоёр. Нүдний тэргүүлэх зэрэг хамгаалах эмчийн тусгай шалгуур:

1. Нүдний резидентийн сургалт дүүргэсэн, хүн амд нүдний шинжлэх ухааны оношлогоо, эмчилгээний тусламжийг төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн хэмжээнд бүрэн үзүүлэх онол дадлагын мэдлэгтэй, сургалт явуулах чадвартай, бүтээлтэй байна.
2. Нүдний эмгэгтэй өвчтөнд нөхөн сэргээх хагалгаа (хиймэл болор суулгах, глауком болон катарактын хавсарсан мэс засал, дакриоцистотоми, зовхи сойх гэх мэт) болон нүдний хэт авиа, флюоресцент ангиографи, СТ, MRI-н онолын мэдлэгтэй буюу хийх ур чадвартай байна.
3. Мэргэжил нэгт эмч нартаа хүндэтгэлтэй харьцдаг, ёс зүйн алдаа гаргадаггүй байх
4. Жил бүр нэгээс доошгүй удаа мэргэжлийн богино хугацааны сургалтанд хамрагдсан байх
5. Англи болон бусад гадаад хэлний мэдлэгтэй, нүд судлалын сэтгүүл, ном, мэдээллийг уншдаг, орчуулга хийх чадвартай байх
6. Мэргэжлийн болон эрүүл мэндийн чиглэлийн сэтгүүлд 5-с доошгүй нийтлэл болон эрдэм шинжилгээний өгүүлэл бичсэн байх

Гурав. Нүдний зөвлөх зэрэг хамгаалах эмчийн тусгай шалгуур:

1. Нүдний резидентийн сургалт дүүргэсэн, хүн амд нүдний шинжлэх ухааны оношлогоо, эмчилгээний төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламжийг бүрэн үзүүлэх онол дадлагын мэдлэгтэй, эрдэм шинжилгээний ажил удирдах чадвартай, оюуны өмчтэй байна.
2. Нүдний эмгэгтэй өвчтөнд нөхөн сэргээх бичил мэс засал (болрын факоэмульсификац, торлогийн мэс засал, витрэктоми, ухархайн хананы репозиц, LASIK гэх мэт) болон нүдний лазер эмчилгээний онолын мэдлэгтэй буюу хийх ур чадвартай байна.
3. Нүдний ховор тохиолдох эмгэгийг ялган оношлох чадвартай
4. Нүдний бусад эмнэлгүүдэд өөрийн мэргэшсэн сэдвээр тусламж үзүүлэх чадвартай, жилд 2-3 удаа бусад эмнэлэгт очиж ажилласан
5. Тэргүүлэх зэргийн эмч нарт багшлах чадвартай
6. Мэргэжил нэгт эмч нартаа хүндэтгэлтэй харьцдаг, ёс зүйн алдаа гаргадаггүй байх
7. Жил бүр нэгээс доошгүй удаа мэргэжлийн богино хугацааны сургалтанд хамрагдсан байх
8. Англи болон бусад гадаад хэлний мэдлэгтэй, нүд судлалын сэтгүүл, ном, мэдээллийг уншдаг, орчуулга хийх чадвартай байх
9. Мэргэжлийн болон эрүүл мэндийн чиглэлийн сэтгүүлд 8-с доошгүй эрдэм шинжилгээний өгүүлэл бичсэн байх

Тайлбар: Зэрэгтэй эмч нь зэргийн нөхцөлд заагдсан мэс заслын багаж, тоног төхөөрөмж, бусад нөхцөл бүрдсэн үед уг мэс заслыг хийх үүрэгтэй